

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/006/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn

Аудитор: О.Энхтөр

Утас: 95343496 Цахим хаяг: enkhturo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 03. 26

№

156

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жаргалан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 30.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
- Орон нутгийн төсвийн хөрөнгийн орлого 11.1 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.0 сая төгрөгөөр тус тус тасарсан.
- Сумын орон нутгийн төсвөөс Соёлын төвд 28.2 сая төгрөг, Эрүүл мэндийн төвд 10.0 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгт 3.7 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дахь заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Р.МӨНХБАЯР ТАНАА

822511000462

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 420.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 435.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 14.3 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар давуулан биелүүлжээ.

Тайлант онд аймгийн төсвөөс 976.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн олгосон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд нийт 416.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Засаг даргын Тамгын газар 23.3 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургууль 69.4 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 45.6 сая төгрөг, Соёлын төв 41.1 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 22.3 сая төгрөгийн халаалтын зардлын өр төлбөртэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 5 хөтөлбөр, 8 зорилт, 46 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хангалттай гэж үнэлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| № | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|----|---|------------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,010,977.0 | 1,145,391.4 |
| 2 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 324,815.0 | 243,291.3 |
| 3 | АВЛАГА | 267,908.1 | 321,455.3 |
| 4 | БАРАА МАТЕРИАЛ | 390,522.2 | 472,959.8 |
| 5 | НӨӨЦИЙН БАРАА | 4,246.8 | 0.1 |
| 6 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 23,485.0 | 107,685.0 |
| 7 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,141,371.4 | 4,210,926.9 |
| 8 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,141,371.4 | 4,210,926.9 |
| 9 | Биет хөрөнгө | 3,393,152.1 | 3,462,090.9 |
| 10 | Биет бус хөрөнгө | 748,219.3 | 748,836.0 |
| 11 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 5,152,348.4 | 5,356,318.3 |
| 12 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 227,360.2 | 416,504.1 |
| 13 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 227,360.2 | 416,504.1 |
| 14 | Өглөг | 227,360.2 | 416,504.1 |
| 15 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,924,988.2 | 4,939,814.2 |
| 16 | Засгийн газрын хувь оролцоо | 4,924,988.2 | 4,939,814.2 |
| 17 | Засгийн газрын оруулсан капитал | 393,328.6 | 393,328.6 |
| 18 | Хуримтлагдсан үр дүн | 4,162,871.3 | 4,177,697.3 |
| 19 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 368,788.4 | 368,788.4 |
| 20 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 5,152,348.4 | 5,356,318.3 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| № | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|----|--|------------------------|------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 2,004,802.6 | 2,083,952.2 |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | 359,361.2 | 433,474.4 |
| 3 | Орлогын албан татвар | 312,075.8 | 332,826.8 |
| 4 | Хувь хүний орлогын албан татвар | 342,880.7 | 350,457.4 |
| 5 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (30,805.0) | (17,630.6) |
| 6 | Хөрөнгийн албан татвар | 40,679.7 | 72,588.5 |
| 7 | Бусад татвар, төлбөр, хураамж | 6,605.7 | 28,059.1 |
| 8 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 449,046.6 | 1,650,477.8 |
| 9 | Тусламжийн орлого | - | 1,016,142.4 |
| 10 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,196,394.8 | - |
| 11 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,929,611.3 | 1,943,984.3 |
| 12 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,929,611.3 | 1,943,984.3 |
| 13 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,878,512.6 | 1,915,357.0 |
| 14 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 633,809.6 | 745,197.8 |
| 15 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 79,456.6 | 95,000.4 |
| 16 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 532,558.5 | 537,287.6 |
| 17 | Хангамж, бараа материалын зардал | 81,579.3 | 42,476.1 |
| 18 | Эд хогшил, урсгал засварын зардал | 65,348.3 | 20,680.5 |
| 19 | Томиллолт, зочны зардал | 16,122.5 | 13,530.0 |
| 20 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 285,921.1 | 271,337.6 |
| 21 | Бараа үйлчилгээний бусад зардал | 183,716.8 | 189,847.2 |

| | | | |
|----|--|-------------|-------------|
| 22 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 51,098.7 | 28,627.3 |
| 23 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 75,191.3 | 139,968.0 |
| 24 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 201,139.2 | 128,353.3 |
| 25 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | (201,139.2) | (128,353.3) |
| 26 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | (125,947.9) | 11,614.6 |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|----|--|--|-------------------------|
| 1 | 2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл | 5,049,207.4 | 5,049,207.4 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,728.7 | 1,728.7 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,050,936.1 | 5,050,936.1 |
| 4 | Тайлант үеийн үр дүн | (125,947.9) | (125,947.9) |
| 5 | 2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл | 4,924,988.2 | 4,924,988.2 |
| 6 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,924,988.2 | 4,924,988.2 |
| 7 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 3,211.4 | 3,211.4 |
| 8 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,928,199.6 | 4,928,199.6 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 11,614.6 | 11,614.6 |
| 10 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 4,939,814.2 | 4,939,814.2 |

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|----|--|------------------------|------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 2,005,963.9 | 2,090,010.2 |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | 359,361.2 | 433,474.4 |
| 3 | Орлогын албан татвар | 312,075.8 | 332,826.8 |
| 4 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (30,805.0) | (17,630.6) |
| 5 | Хөрөнгийн албан татвар | 40,679.7 | 72,588.5 |
| 6 | Бусад татвар, төлбөр, хураамж | 6,605.7 | 28,059.1 |
| 7 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 1,322.3 | 2,905.2 |
| 8 | Газрын төлбөр | 5,283.4 | 6,183.6 |
| 9 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | - | 18,970.3 |
| 10 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 450,207.9 | 1,656,535.8 |
| 11 | Нийтлэг татварын бус орлого | 450,207.9 | 497,665.3 |
| 12 | Тусламжийн орлого | - | 1,016,142.4 |
| 13 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | 142,728.1 |
| 14 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,196,394.8 | - |
| 15 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,898,722.8 | 2,008,848.1 |
| 16 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,898,722.8 | 2,008,848.1 |
| 17 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,847,624.1 | 1,980,220.9 |
| 18 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 780,733.2 | 879,239.2 |
| 19 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 111,807.4 | 95,743.8 |
| 20 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 420,257.3 | 550,722.5 |
| 21 | Хангамж, бараа материалын зардал | 197,896.5 | 220,007.2 |

| | | | |
|----|--|-------------|-------------|
| 22 | Эд хогшил, урсгал засварын зардал | 73,916.4 | 20,680.5 |
| 23 | Томилолт, зочны зардал | 16,122.5 | 14,242.8 |
| 24 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 187,739.6 | 170,816.3 |
| 25 | Бараа үйлчилгээний бусад зардал | 59,151.3 | 28,768.6 |
| 26 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 51,098.7 | 28,627.3 |
| 27 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 107,241.1 | 81,162.1 |
| 28 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 213,419.0 | 162,685.8 |
| 29 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 213,419.0 | 162,685.8 |
| 30 | Дотоод эх үүсвэрээр | 213,419.0 | 162,685.8 |
| 31 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (213,419.0) | (162,685.8) |
| 32 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 70,150.0 | - |
| 33 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (70,150.0) | - |
| 34 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | (176,327.9) | (81,523.7) |
| 35 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 501,142.9 | 324,815.0 |
| 36 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 324,815.0 | 243,291.3 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| Код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|--|-------------|-------------|------------|-------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 1,824,372.2 | 1,595,532.8 | 228,839.4 | 87.5 |
| 11 | Татварын орлого | 420,233.4 | 439,713.2 | (19,479.8) | 104.6 |
| 110 | Орлогын албан татвар | 342,733.4 | 339,065.6 | 3,667.8 | 98.9 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 360,364.0 | 356,696.2 | 3,667.8 | 99.0 |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 264,665.2 | 261,265.4 | 3,399.8 | 98.7 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 12,824.3 | 15,642.7 | (2,818.4) | 122.0 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 51,904.2 | 40,759.3 | 11,144.9 | 78.5 |
| 110008 | Шууд бус орлого | 30,970.3 | 30,970.3 | 0.0 | 100.0 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (17,630.6) | (17,630.6) | (0.0) | 100.0 |
| 110101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (17,630.6) | (17,630.6) | (0.0) | 100.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 51,500.0 | 72,588.5 | (21,088.5) | 140.9 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 5,000.0 | 6,168.4 | (1,168.4) | 123.4 |
| 113002 | Бууны албан татвар | 1,500.0 | 3,247.0 | (1,747.0) | 216.5 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 45,000.0 | 63,173.0 | (18,173.0) | 140.4 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 4,500.0 | 2,905.2 | 1,594.8 | 64.6 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 1,000.0 | 1,467.6 | (467.6) | 146.8 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 3,500.0 | 1,437.6 | 2,062.4 | 41.1 |
| 1181 | Газрын төлбөр | 3,500.0 | 6,183.6 | (2,683.6) | 176.7 |
| 118101 | Газрын төлбөр | 3,500.0 | 6,183.6 | (2,683.6) | 176.7 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 18,000.0 | 18,970.3 | (970.3) | 105.4 |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 18,000.0 | 18,685.3 | (685.3) | 103.8 |

Жаргалан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | | |
|--------|--|-------------|-------------|------------|---------|
| 12 | Татварын бус орлого | 1,404,138.8 | 1,155,819.6 | 248,319.2 | 82.3 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 36,590.0 | 36,893.3 | (303.3) | 100.8 |
| 120003 | Торгуулийн орлого | 625.0 | 1,720.0 | (1,095.0) | 275.2 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 1,900.0 | 29,471.3 | (27,571.3) | 1,551.1 |
| 122 | Тусламжийн орлого | 1,224,820.7 | 976,198.2 | 248,622.5 | 79.7 |
| 122003 | Аймаг нийслэлээс авсан татаас | 976,198.2 | 976,198.2 | - | 100.0 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 142,728.1 | 142,728.1 | - | 100.0 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 142,728.1 | 142,728.1 | - | 100.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,824,372.2 | 1,595,532.8 | 228,839.4 | 87.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,485,956.6 | 1,432,847.0 | 53,109.6 | 96.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,444,466.6 | 1,404,219.7 | 40,246.9 | 97.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 766,350.0 | 736,210.5 | 30,139.5 | 96.1 |
| 210101 | Үндсэн цалин | 245,400.0 | 328,585.7 | (83,185.7) | 133.9 |
| 210102 | Нэмэгдэл | 438,430.0 | 350,675.3 | 87,754.7 | 80.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 51,200.0 | 20,306.8 | 30,893.2 | 39.7 |
| 210104 | Урамшуулал | 31,320.0 | 36,642.7 | (5,322.7) | 117.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 95,743.8 | 95,743.8 | - | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,143.8 | 70,143.8 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,400.0 | 6,400.0 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,200.0 | 3,200.0 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,200.0 | 3,200.0 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,800.0 | 12,800.0 | - | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 430,767.8 | 470,600.7 | (39,832.9) | 109.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 33,738.0 | 24,586.3 | 9,151.7 | 72.9 |
| 210302 | Түлш, халаалт | 391,029.8 | 430,714.4 | (39,684.6) | 110.1 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,000.0 | 15,300.0 | (9,300.0) | 255.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 47,400.0 | 26,903.8 | 20,496.2 | 56.8 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,300.0 | 3,825.9 | 4,474.2 | 46.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,000.0 | 14,015.6 | 10,984.4 | 56.1 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,600.0 | 2,359.5 | 1,240.5 | 65.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,500.0 | 6,702.9 | 3,797.2 | 63.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 33,200.0 | 20,680.5 | 12,519.6 | 62.3 |
| 210604 | Урсгал засвар | 33,200.0 | 20,680.5 | 12,519.6 | 62.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 16,000.0 | 14,242.8 | 1,757.2 | 89.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 16,000.0 | 14,242.8 | 1,757.2 | 89.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 15,055.0 | 11,069.2 | 3,985.9 | 73.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,000.0 | 10,394.7 | 605.3 | 94.5 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 800.0 | 234.5 | 565.6 | 29.3 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,500.0 | 440.0 | 1,060.0 | 29.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,950.0 | 28,768.6 | 11,181.4 | 72.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,950.0 | 28,768.6 | 11,181.4 | 72.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 41,490.0 | 28,627.3 | 12,862.8 | 69.0 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 33,990.0 | 23,166.0 | 10,824.0 | 68.2 |

| | | | | | |
|--------|---|-----------|-----------|----------|------|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,500.0 | 5,461.3 | 2,038.8 | 72.8 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 225,721.3 | 162,685.8 | 63,035.5 | 72.1 |
| 223001 | Бусад хөрөнгө | 225,721.3 | 162,685.8 | 63,035.5 | 72.1 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| Дансны код | Дансны нэр, төрөл | Дүн |
|------------|--|-----------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 108,130.8 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 108,130.8 |
| 122 | Тусламжийн орлого | 108,130.8 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 108,130.8 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 108,130.8 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 107,675.8 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 455.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 102,428.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 102,428.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 102,428.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,911.8 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,821.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 90.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 96,517.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 96,517.0 |
| 4 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,702.0 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Жаргалан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 1 аж ахуй нэгж, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт, Суурин дулаан ААТҮГ-ын санхүүгийн тайланд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн ба сумын ИТХ, ХХС, БХНСС, ОНХС, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

3.1 Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 95.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 2 алдааг залруулж, 0.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 13.6 сая төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналыг 294.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 7 алдааг залруулж, 16.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон байна.

3.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулагдаагүй нийт 55.2 сая төгрөгийн, харьяа байгууллагуудын аудитаар 30.5 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн нь тогтоосон материаллаг байдлын түвшингээс их бөгөөд зөрчлийн шинж чанарыг харгалзан үзэж "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн нийт 55.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 55.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлсэн.

3.3.1 Албан шаардлага

Нэг. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 30.5 сая төгрөгийн 5 зөрчил илэрч, 16.9 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13.6 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж холбогдох байгууллагад хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Нэг. Орон нутгийн орлогын төлөвлөгөөгөөр хөрөнгийн орлого 11.1 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.0 сая төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", "Жаргалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолтой нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэлийг хангуулж ажиллах.

Хоёр. Сумын орон нутгийн төсвөөс Соёлын төвд 28.2 сая төгрөг, Эрүүл мэндийн төвд 10.0 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгт 3.7 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 41 дүгээр зүйлийн 41.1-т "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх"; "Жаргалан сумын Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дүгээр тогтоолтой нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгаас олгосон санхүүжилтийг төлөвлөгөөний дагуу хуваарилах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Жаргалан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

| 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | (мянган төгрөг) | |
|---|------------|--------------------|-----------------------------------|------------------|--------------------------|------------------|-----------|--------------------|-----------------|--------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | Залруулаагүй |
| Жаргалан сумын ЗДТГ | 2 | 95,482.4 | - | - | 2 | 95,482.4 | 2 | 95,482.4 | - | - |
| Жаргалан сумын ИТХ | 1 | 6,032.1 | - | - | 1 | 6,032.1 | 1 | 6,032.1 | - | - |
| Жаргалан сумын ОНХС | 3 | 247,224.9 | - | - | 3 | 247,224.9 | 3 | 247,224.9 | - | - |
| Жаргалан сумын ХХС | 3 | 40,962.2 | - | - | 3 | 40,962.2 | 3 | 40,962.2 | - | - |
| Жаргалан сумын Суурин дулаан | 2 | 636,345.8 | 1 | 265,796.6 | 1 | 265,796.6 | 2 | 636,345.8 | - | - |
| Дүн | 11 | 1,026,047.4 | 1. | 265,796.6 | 10 | 760,250.8 | 11 | 1,026,047.4 | - | - |

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---------------------------|-------------|----------|---------------|-----------------|-----------------|-----------------|----------|----------|--------------------------------------|----------|---|----------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Жаргалан сумын ТТЗ | 1 | - | 3 | 55,227.6 | - | - | 1 | - | 2 | 55,226.6 | - | - |
| Жаргалан сумын ЗДТГ | 1 | - | 3 | 14,536.4 | 1 | 873.8 | - | - | 2 | 13,662.6 | - | - |
| Жаргалан сумын ИТХ | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Жаргалан сумын ОНХС | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Жаргалан сумын БХНСС | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Жаргалан сумын ХХС | 1 | - | 1 | 16,020.7 | 1 | 16,020.7 | - | - | - | - | - | - |

Жаргалан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | | | | | | | | | |
|----------------------------------|---|---|---|---|---|---|----------|---|----------|---|---|------------|
| Жаргалан сумын Суурин дулаан Дүн | 1 | 1 | - | - | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| | 7 | 1 | 2 | - | 4 | 8 | 85,784.7 | 2 | 16,894.5 | 1 | - | 5 68,889.2 |

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------------|---------------------|-------------------|---------------|-------------------------|---------|-------------------------------|--|--|--|
| | | | 2 Аудитад хамрагдах | 3 Санал дүгнэлт гаргасан | 4 Түвэрт хамруулсан | 5 Аудит хийгээгүй | 7 Өөрчлөлтийн | 8 Хязгаарлалттай | 9 Сөрөг | 10 Дүгнэлт өгөхөөс татгалзсан | | | |
| A | 1 | | | | | | | | | | | | |
| 1 | ТТЗ | | 1 | | | | | | | 1 | | | |
| | НИЙТ | | 1 | | | | | | 1 | 1 | | | |